

хилчдийн бодлого үйл ажиллагааны үндэс нь болж байх тавилантай юм. Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогод “хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны үндэс болгох”-оор дэвшигдсэн зорилт аажим боловч үр дүнтэй хэрэгжсээр байна.

Сургалт-эрдэм шинжилгээнээс эрдэм шинжилгээ-сургалтын шинэ тогтолцоонд шилжиж орсны үндсэн шалтгааны нэг нь манай их сургуулийн бүтээгдэхүүн болох офицерууд зөвхөн сайн захирагч, бүтээлч дарга, өндөр мэргэжилтэн, шалгарсан менежер байх төдийгүй төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогыг төгс болгох, түүнийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэгч өндөр зэрэглэлийн судлаачид, шинэ арга технологийг санаачлагчид байх ёстой гэж үзэж байна.

Энэ байр сууринаас авч үзвэл бидэнд шийдвэрлэх,

хийх ёстой тулгамдсан асуудлууд эрдэм шинжилгээ, сургалт аль алинд ч цөөнгүй байгаа нь эргэлзээгүй.

Ном зүй

1. Улсын хил хамгаалалтын түүхэн сургамж 80 жил. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. ХХЕГ. УБ., 2013 он
2. Ш.Доржбал. Хилээр овоглосон сургууль. УБ. 2004 он
3. Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Эмхэтгэл II. УБ., 2013 он
4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. Монгол улсын олон улсын гэрээ. Төрийн мэдээлэл тусгай дугаар I боть. УИХ-ын Тамгын газар, ГХЯ. УБ., 2004 он
5. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. ХХЕГ. УБ, 2002 он

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООНД ХИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЖИЛЛАГААНЫ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ: POTISION OF THE BORDER REPERESENTATIVES IN BORDER PROTECTION STRUCTURE AND ITS PROMOTION



Ц.Ганболд. ХСИС-ийн Хилийн сургуулийн захирал, цэргийн ухааны доктор, профессор, хурандаа
Ganbold.Ts. Director of Border Troops Institute, Law Enforcement Institute, Ph.D, Professor, Colonel

Abstract: Military politics than by any issue through diplomacy, agreement, consensus and wisdom to address current conditions prevalent in the border regime enforcement, border violations, incidents decision regulate Mongolian border delegate of great responsibility, and he has draft.

Улсын хил хамгаалалт нь хилийн дэглэмийн, хил орчмын дэглэмийн, цэргийн, инженер техникийн, улс төрийн, дипломатын, эдийн засгийн, тагнуулын арга хэмжээнээс бүрдэнэ. Монгол Улсын хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрэмд “Хилийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тогтоосон дэглэмийг сахиулах, улсын хил дээр зөрчил, будлиан гарахаас сэргийлэх, хил дээр үүссэн хилийн аливаа асуудлыг

шуурхай шийдвэрлэх зорилгоор хилийн цэргийн байнгын бүрэлдэхүүнээс тусгайлан томилогдсон офицеруудын хүчээр хил залгаа улсын хил хамгаалах байгууллагатай хамтран явуулж буй дипломат арга хэмжээг хилийн төлөөлөгчийн ажиллагаа» гэх бөгөөд улс орны эрх ашгийг улсын хил дээр хамгаалах арга хэлбэрийн нэг юм” гэж заажээ.

Монгол Улсын хилийн төлөөлөгчийн

ажиллагаагаар буюу улс төр-дипломатын аргаар улсын хил хамгаалах нь хил хамгаалалтын тогтолцоонд байр сууриа эзэлж, тодорхой хувь нэмрээ оруулж “Хилийн асуудлыг шийдвэрлэхдээ хүч хэрэглэхээс аль болох зайлсхийх, энхийн аргаар шийдвэрлэх” нь чухал болж байна.

Хилийн төлөөлөгч нь тодорхой хариуцсан хэсэг дээрээ үйл ажиллагаа явуулах боловч эцсийн үр дүн нь хөрш зэргэлдээ улстай хэвийн харилцааг хангахад чиглэгдэх ёстой.

Энэ нь геополитик, стратегийн байршил талаас нь авч үзвэл дэлхийн бодлогыг тодорхойлдог цөмийн зэвсэг бүхий хоёр өөр соёл иргэншилтэй, хоёр том гүрний дунд оршдог Монгол орны хувьд онц чухал юм.

Монгол Улсын хилийн төлөөлөгч нь улсын хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчил, будлиан үүсэхээс урьдчилан сэргийлж, хилийн зөрчил будлианыг зэвсэгт мөргөлдөөнд хүргэхгүй, цаг алдалгүй түргэн шуурхай шийдвэрлэх, хохирлыг барагдуулах үүргийг хүлээдэг.

Монгол Улсын хилийн төлөөлөгчийн гүйцэтгэх үүргийг түүний хамрах хүрээ, үйл ажиллагааны төрлөөр нь дараах үндсэн гурван бүлэгт хувааж болох юм.

1. Хилийн зөрчил будлианаас сэргийлсэн чанартай үүрэг:

Хилийн дэглэмийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг хатуу сахих, улсын хилийн дэглэм зөрчихөөс урьдчилан сэргийлсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, зэргэлдээ улсын хилийн төлөөлөгчидтэй байнгын харилцаатай байж, хилийн зөрчил будлиан гаргахгүй байхтай холбогдсон арга хэмжээнүүд

2. Хилийн зөрчил, будлианыг тайван замаар шийдвэрлэх үүрэг:

Зэргэлдээ улсын хилийн төлөөлөгчтэй хамтран нэгэнт гарсан хилийн зөрчил, будлианыг зохицуулах, зогсоох талаар хэлэлцээ хийх, хилийн зөрчил, будлианы улмаас бий болсон хохирол, гомдлыг судлан шийдвэрлэж, барагдуулах

3. Хяналт шалгалтын чанартай үүрэг:

Хилийн төлөөлөгчийн уулзалтаар гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах, гарсан хохирлыг шийдвэрлэсэн, барагдуулсан байдлыг хянах асуудлыг багтааж байна.

Монгол Улсын хилийн төлөөлөгчийн ажиллагааг боловсронгуй, үр дүнтэй болгох асуудлын хүрээнд:

1. Хилийн төлөөлөгчийн ажиллагааны хилийн асуудлыг шийдвэрлэх, зохицуулах гэрээ эрхийн орчинг төгөлдөржүүлэх.

Монгол Улсын Хилийн тухай хуулиар Монгол Улсын хилийг тогтоох, тодорхойлох, өөрчлөх асуудлыг Монгол Улсын Их Хурал, улсын хилийг хамтран шалгах асуудлыг Монгол Улсын Засгийн

газар хариуцаж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг улсын хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хилийн асуудлыг зохицуулах үүрэг Монгол Улсын хилийн төлөөлөгчид ноогддог.

Монгол Улсын өмнө зүгийн хил нь БНМАУ, БНХАУ-ын хооронд 1962 онд байгуулсан хилийн гэрээгээр тодорхойлогдож тогтоогдон 1975 онд НҮБ-д бүртгэгдэж олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн. 1988 онд Монгол-Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай гэрээ, 1991 онд Монгол-Хятадын хилийн боомтын дэглэм, хил орчмын иргэд харилцан зорчих тухай хоёр улсын Засгийн Газар хоорондын хэлэлцээрүүд байгуулагдсанаар гэрээ, эрх зүйн зохицуулалттай болсон билээ.

Монгол Улсын хойд хил нь БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1958, 1976 онд байгуулагдсан хилийн гэрээнүүдээр тодорхойлогдон тогтоогдож, 1980 оны Монгол-Оросын хилийн дэглэм, хилийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай гэрээ, Монгол-Оросын хилийн боомтын дэглэм, улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай хоёр улсын Засгийн Газар хоорондын 1988 оны хэлэлцээрүүдээр эрх зүйн зохицуулалттай болсон боловч энэ хүрээнд дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай.

Тухайлбал:

Монгол-Оросын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулах тухай Засгийн газар хоорондын гэрээг шинэчлэх;

Монгол-Оросын хилийг НҮБ-д бүртгүүлэн баталгаажуулах;

Монгол-Хятадын хилийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах;

Дэлхийн шим мандлын бүс, олон улсын дархан цаазтай газрын хилийн хамгаалалтын асуудлын талаар зэргэлдээ улсуудтай хамтарч гэрээ, хэлэлцээр байгуулах.

Мөн дотоодод эдгээр асуудлын хүрээнд:

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын хэмжээнд авч үзэх, уг үзэл баримтлалд тусгах;

Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад оролцогч бүх байгууллага, иргэдийн ажлын уялдаа холбоог зохицуулах тухай Засгийн Газрын тогтоол гаргах;

Хилийн бүс, зурваст байгуулагдах Алтанбулаг-Замын-Үүд, Цагааннуурын эдийн засгийн чөлөөт бүс, түүнийг зохицуулах хуулинд хил хамгаалах байгууллагын оролцоо, эрх, үүргийг хуульчлан тусгах, эдийн засгийн чөлөөт бүсийн хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх ажиллагааг хилийн цэрэг гүйцэтгэх ёстойг энд зориуд тэмдэглэе.

2. Монгол Улсын хилийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнийг удирдлага, зохион байгуулалт,

бүтцийг өөрчлөн шинэчлэх, боловсронгуй болгох.

Монгол Улсын хилийн төлөөлөгч, түүний бүрэлдэхүүн нь орон тооны бус өөрийн албан тушаалын үндсэн үүрэгтэйгээр хавсран гүйцэтгэдэг бөгөөд Хил Хамгаалах Ерөнхий Газрын дарга, штабын даргад шууд захирагдан мэдээ, мэдээлэл, өдөр тутмын үйл ажиллагааны хувьд Хил хамгаалах ерөнхий газрын дарга, түүний уулзалт хариуцсан офицерт захирагдан ажилладаг.

Манай хөрш, бид, энд үлгэр дууриалал болдог, туршлагыг нь байнга авч хэрэгжүүлдэг ОХУ-д хилийн төлөөлөгчийн ажиллагааг орон тооны мэргэшсэн бүрэлдэхүүнээр явуулдаг болсоор удаж байна. Хилийн отрядын даргын хилийн төлөөлөгчийн ажиллагаа хариуцсан орлогч энэ ажлыг хариуцан бүс нутгийн удирдах газрын олон улсын гэрээ эрх-хилийн төлөөлөгчийн ажиллагааг удирдах хэлтсийн даргад захирагдан ажиллаж байна.

Дэвшүүлж буй санаа бол:

- а/ Монгол Улсын хилийн төлөөлөгчийн ажиллагааг мэргэшсэн орон тооны бүрэлдэхүүнээр явуулах, мэргэжлийн сургалтад хамруулдаг байх
- б/ Хил хамгаалах газарт хилийн төлөөлөгчийн ажиллагаа, олон улсын гэрээ эрхийн албыг Олон улсын эрх зүйн хүрээнд эрх үүргээ хэрэгжүүлэн ажиллах, Монгол Улсын хилийн төлөөлөгчийн ажиллагааг бие даасан мэргэжлийн удирдлагаар хангах зорилготойгоор байгуулах
- в/ Гадаад Харилцааны Яамны хилийн тасаг, хил хамтран шалгах комисстой нягт хамтран ажилладаг байх
- г/ Хилийг хамтран шалгах Монголын талын комиссыг байнга ажиллуулан хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, эрхийн биелэлтэд мэргэжлийн хяналт тавих, туслах үүрэг гүйцэтгүүлэхийн зэрэгцээ дараагийн хилийн хамтын шалгалтад шаардагдах бүх бэлтгэлийг урьдчилан хангуулж, тогтоосон хугацаанд багтаан улсын хилийн хамтарсан шалгалт явуулдаг байх байнгын ажиллагаатай болгох. Энэ комисс, хилийн төлөөлөгчийн ажиллагааг удирдах албаны бүтцэд ч байж болох юм.
- д/ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, мянганы замын босоо, хэвтээ тэнхлэг болон дэд бүтцийн хөгжлийн стратегийн хэтийн төлөвийг харгалзан хилийн төлөөлөгчийн байгууллага-хилийн төлөөлөгчийн газрыг бүсчилсэн хөгжлийн тулгуур төвүүдийг түшиглэн байгуулан ажиллуулах нь аливаа асуудлыг улс төр-дипломатын аргаар, энхийн журмаар шийдвэрлэдэг байдал давамгайлж байгаа энэ үед ихээхэн ач холбогдолтой бөгөөд цаашид хилийн төлөөлөгчийн ажиллагаа нь хилийн асуудлыг зохицуулах, шийдвэрлэх үндсэн арга нь болохыг харгалзан үзэх шаардлагатай байна. Өмнө нь байгуулагдаж байсан хилийн

төлөөлөгчийн газрын бааз, суурийг харгалзах бөгөөд гэхдээ мэдээж ажиллагаа, эрх, үүргийн хувьд илүү өргөн, харъяа отрядчуудын үйл ажиллагааг чиглүүлэх, хянах, зааварлах, шалган туслах үүрэг бүхий оператив удирдлагын нэгжийн үүргийн зэрэгцээ харъяа хилийн төлөөлөгчийг удирдана. Харъяа отрядын дарга нар хилийн төлөөлөгчийн орлогчийн хэмжээнд ажиллаж болох юм.

Хилийн төлөөлөгчийн газар нь бэлтгэл хүчтэй, хангалтын баазтай, нисдэг тэрэгтэй, нэгдсэн хангалт үйлчилгээ, засварын бааз, хэрэг бүртгэх, тагнуулын албатай, өөрөөр хэлбэл бүс нутагт хилийн цэргийн удирдлагыг хангах үүрэгтэй, цэргийг удирдах өдөр тутмын үйл ажиллагаанаас нь ХХЕГ-ыг ангижруулсан, хил хамгаалалтын талаарх төр, улсын бодлогыг боловсруулахад нь тус болохуйц харъяа отрядчуудын өдөр тутмын бүхий л асуудлыг шийдвэрлэдэг удирдлагын бие даасан нэгж байх ёстой гэж үзэж байна.

3. Хилийн төлөөлөгчийн бие даасан байдал, нэр хүнд, нөлөөг дээшлүүлэх:

- Монгол Улсын хилийн төлөөлөгчийг хилийн асуудлаарх Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хилийн тухай хуулийн заалтын дагуу Монгол Улсын Засгийн газраас томилох;
- Хилийн төлөөлөгчид дипломат ажилтны нэмэгдэл /цалин, тодорхой хувь/ олгох;
- Дипломат зэрэг дэв олгодог байх асуудлыг судлан шийдвэрлэх;
- Бүрэн эрхийн хугацаанд нь дипломат, эсвэл албан гадаад паспорт эзэмшүүлэх;
- “Монгол Улсын хилийн төлөөлөгч” гэсэн тэмдэг биш соёмбо эсвэл төрийн сүлдтэй тамга хэрэглэдэг болгох;
- Хоёр хөрштэйгээ харилцан тэгш эрхтэй харилцах бодлогыг хэрэгжүүлэх үүднээс өмнөд ба хойд хилд “Хилийн төлөөлөгч”, “Хилийн бүрэн эрхт төлөөлөгч” гэж байгааг нэг мөр болгон “Монгол Улсын хилийн бүрэн эрхт төлөөлөгч” гэж нэрлэх, холбогдох гэрээнд өөрчлөлт оруулах;
- Хилийн цэргийн бусад бие бүрэлдэхүүнээс ялгах онцлог тэмдэг хэрэглэх.

Энэ онцлог тэмдгийг томилогдсон үед нь үнэмлэхийн хамт олгож, өөрчлөгдсөн үед хураан авах, тодорхой тоотой, хувийн дугаартай үйлдвэрлэн, хатуу хяналттай олгоно.

4. Хилийн төлөөлөгчийн ажиллагааны арга, хэлбэрүүдийг нэг хэв загвараас гаргах:

Хилийн төлөөлөгчийн ажиллагааны арга хэлбэрүүдийг хослуулан хэрэглэх, цаг үедээ тохирсон шинэ агуулгаар баяжуулах тал дээр бид санаачилгатай ажиллах ёстой.

Хилийн төлөөлөгчийн ажиллагаа нь Монгол Улсын хил хамгаалалтын үндсэн аргуудын нэг нь болж дүрэм, заавраар зохицуулагдах ажиллагаа 1953 онд “Монгол Улсын хилийн төлөөлөгчийн ажиллах заавар” батлагдсаар хууль эрх зүйн хүрээнд

албан ёсоор баталгаажин хэрэглэгдэж иржээ. Монгол Улсын хилийн төлөөлөгчийн ажиллах дүрэм, зааврууд 1957, 1969, 1994, 2007 онуудад шинэчлэгдэн батлагдаж иржээ.

ХИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ СУРГАМЖУУД:

1956 онд Монгол-Оросын хилийн төлөөлөгчдийн уулзалтаар Цагааннуур-Ташанта хоёр боомтын хооронд хилийн төлөөлөгчийн утсан холбоо тавихаар яригдсаар жилийн дараа шийдвэрлэгдсэн боловч холбоотой явсаар 40 жилийн нүүр үзэж 1995 онд энэ холбоог мөн л олон удаа ярилцсаны эцэст ажилд оруулан үр ашиггүй нааш, цааш явалт, хугацааг багасгаж, хилийн төлөөлөгчид утсаар ажлаа амжуулж байсан билээ. Одоо ямар байгааг мэдэхгүй.

1952-1962 он хүртэлх өмнөд хил дээр явагдсан хилийн төлөөлөгчдийн уулзалтуудын материал дээр судалгаа хийж үзэхэд манай талаас өөрийн хятад хэлний орчуулагчтайгаар уулзалт хийсэн тохиолдол маш цөөхөн бөгөөд "Нот" гэдэг үгийг ойлгуулах гэж цөхрөнгөө бараад орхиж байсан байх жишээтэй. Ялимгүй, бүр санаанд оромгүй зүйл, онож хэлээгүй үг яриа, дохио зангаа, орчуулгаас болж алдаж эндвэл улс орны ашиг сонирхолыг хохироход ч хүрдэг аюултай. Бид дандаа хүний орчуулагчаар дамжуулан орчуулганд өөрсдөө хяналт тавих боломжгүй, санал бодлоо санаандаа тултал илэрхийлэх бололцоогүй, дэмий л зөв орчуулж байгаа болов уу, үгүй болов уу гэж хардсаар өдийг хүрлээ шүү дээ.

Хятад хэлний орчуулагчаар хилийн гол гол боомтуудад ажилладаг хилийн төлөөлөгчийг хангах, хэрвээ тодорхой бодлогогүй явбал хэдэн жилийн дараа ОХУ-д сургууль төгсөгчид тэтгэвэрт гарсны дараа энэ байдал Монгол-Оросын хил дээр давтагдахыг үгүйсгэж болохгүй.

Хоёр улсын харилцаанд хувь хүний хүчин зүйл чухал нөлөөтэй байдаг. Улс хоорондын хэмжээний асуудал мөртлөө хувь хүмүүсийн бие биеэ ойлголцсон, сайн харьцаа эцсийн эцэст асуудлыг зөвөөр шийддэг. Уулзалт хэлэлцээний үед биеэ хэрхэн авч явсан, харилцах урлаг, зөв хооллох, ширээг засах, нэрийн хуудас солилцох, куверт хэрэглэх гээд л хөрш орнууд төдийгүй бусад орны зан заншил ёс журмыг сайтар мэдэж, эзэмших нь уулзалт хэлэлцээний үед эцсийн шийдвэрийг эерэгээр гарахад гол нөлөөтэй гэдгийг онцгойлох ёстой.

Тухайлбал: 1950-60-аад оны үед гэрээ хэлэлцээрээр хил даван нутаглах, өвс хадлан бэлтгэх гээд өргөн харилцаатай байсан энэ үед хилийн төлөөлөгчийн уулзалтад орон нутгийн засаг захиргааны удирдлагуудаас ихээхэн оролцуулдаг байжээ. Дорноговь аймгийн нэгэн даргын биеэ буруу авч яваа, хувийн соёлгүй, бүдүүлэг харьцаанаас болж уулзалтын уур амьсгал буруугаар эргэж байсан

тохиолдол ч байна.

а. Хилийн уулзалт, хэлэлцээний үр дүн, чанарт анхааръя. Түүвэр жишээ: 1999 оны байдлаар Монгол-Хятадын хилд нийт 371 удаагийн уулзалт хэлэлцээ хийснээс төлөөлөгчийн хэмжээнд 19, орлогчийн хэмжээнд 42, туслахын хэмжээнд 310 удаа болжээ.

Монгол-Оросын хилд нийт 130 удаагийн уулзалт хэлэлцээ хийснээс хилийн төлөөлөгчийн хэмжээнд 10, орлогчийн хэмжээнд 10, туслахын хэмжээнд 110 удаа, нийт 481 удаа уулзалт болжээ. Үүнээс үзэхэд хилийн төлөөлөгчдийн ажиллагаа идэвхжин, үүсэн бий болсон асуудлыг шуурхай шийдвэрлэж байгаа өндөр тоон үзүүлэлт өөрөөр хэлбэл жилийн 365 хоногоор тооцвол нэг өдөрт 1,3 уулзалт ноогдож байгаа боловч улсын хилийн зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлт, бууралттай нь холбон авч үзвэл чанарын хувьд зохих хэмжээнд хүрээгүй гэсэн дүгнэлт гарч тооноос чанарт шилжих зүй тогтлыг мөрдөх шаардлага гарч байна.

Сүүлийн үед улс төрч, дипломатууд уулзалт, хэлэлцээ, яриаг их л энгийн нөхцөлд явуулж бие биеэ харилцан ойлголцоход илүү дөхөм хэлбэрүүдийг сонгож байгааг ч бид хэрэглэх нь зүйтэй.

Энэ бол "Зангиагүй уулзалт" гэж олон улсын харилцаанд хэрэглэгдэх болсон хэлбэр юм. Зангиагүй уулзалт хэт албархаг бус, чөлөөтэй эерэг байх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх бололцоог хангасан, даруухан нөхцөл байдалд уулзалт, албан яриа явуулах хэлбэр юм.

Өмнөд хөрш БНХАУ нь хил хамгаалалтандаа инженер-техникийн хамгаалалт, хилийн төлөөлөгчийн ажиллагааны аргыг, хойд хөрш ОХУ улсын хилийг тагнуул, хилийн төлөөлөгчийн ажиллагааны аргуудаар хамгаалахад онцгой анхаарч байгааг бид тооцох ёстой.

Манай улс нь улсын хилийг байнгын харуулаар голлон хамгаалж тодорхой үр дүнд хүрч, онол практикийн асуудлууд нь үндсэндээ шийдвэрлэгдэж үр дүнгээ өгч байгаагийн зэрэгцээ өргөн уудам нутаг дэвсгэр, хөрөнгө төсвийн хомс нөхцөл, цагийн байдлын энэ их өөрчлөлт, өрнөлттэй үед бага зардлаар, бага хүчээр илүү үр дүн гарган улсын хилийг хамгаалж болох хилийн төлөөлөгчийн ажиллагаа, дипломатын аргаар хослуулан хамгаалахад чиглэгдсэн арга хэмжээнд онцгой анхаарах ёстой.

б. Монгол Улсын хилийн төлөөлөгчийн ажиллагааг хил залгаа болон бусад орны хил хамгаалах байгууллагатай тогтоосон уялдаа холбоог сайжруулах

Энэ нь нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлсэн нэг юмны хоёр тал шүү дээ.

ХХЕГ нь Монгол Улсын гадаад харилцааны байгууллагуудын хүрээнд тодорхой салбараар улсаа төлөөлдөг байгууллагуудад хамаарагддаг бөгөөд улсаа өөрийн тодорхой салбараар өөрөөр хэлбэл улсын хилийн асуудлаар төлөөлдөг.

Гадаад улсын зохих байгууллагатай холбоо

тогтоож, өөрсдийн эрх мэдлийн хүрээнд гэрээ, хэлэлцээр байгуулдаг үйл ажиллагаа нь мэргэжлийн шинж чанартай байдаг.

“Хилийн харилцаа” гэж хилийн асуудал, эрх ашгаар холбогдсон улс хоорондын болон тус улсын байгууллага, түүнчлэн иргэдийн хооронд оршиж байгаа, үүсч болох харилцан ажиллагаа, холбоо шүтэлцээтэй нэгдэл юм”. гэж докгор Ш.Арвай тодорхойлжээ.

Хилийн харилцаа нь гадаад ба дотоод харилцаанаас бүрдэж, өөрсдийн харилцааны субъектуудтай байна.

Орчин үеийн нөхцөлд олон улстай хилийн гадаад харилцааг өргөн дэлгэр болгох, хөгжүүлэх зүй ёсны шаардлага тулгарч байгааг дараах чиглэл, хүрээнд өргөжүүлэх нь зүйтэй санагдана.

а/ Гадаад харилцааны хүрээнд:

- Олон улсын хилийн алба, хил судлалын холбоо, байгууллагад гишүүнээр элсэх, хөрш болон бусад улсуудын ижил төстэй байгууллагуудтай ажил төрлийн холбоо тогтоож хамтран ажиллах;
- Хөрш ОХУ-ын Кызыл, Улан-үд, Чита, БНХАУ-ын Бээжин, Хөх хот, Урумчи хотуудад хилийн албан ёсны төлөөлөгч суулгах;
- Хөрш орнууд төдийгүй АНУ, Япон, Солонгос, Израиль, Герман, Египет, Энэтхэг, Сингапур болон бусад орнуудтай хилийн харилцааг, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, туршлага судлах, зэвсэг, техник, технологийг сайжруулах чиглэлээр хөгжүүлэх;
- Монгол Улсын хилийн цэргийг олон улсын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаа, сургалтад

дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх, хил дамнасан хар тамхины наймаа, гамшиг хөнөөлтэй тэмцэх чиглэлээр хамруулах;

- Харилцан ашигтай хилийн худалдааг өргөжүүлэх.

б/ Дотоод харилцааны хүрээнд:

- Хилийн асуудлаар дотоод харилцааны хүрээний байгууллагуудын шуурхай мэдээллийн сүлжээг байгуулах.
- Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх.

Хил хамгаалах байгууллагын стратегийн 8 зорилтын 3 нь хилийн төлөөлөгчийн ажиллагааг боловсронгуй болгохтой шууд холбогдож байгаа юм. Үүнд:

1. Улсын хил хамгаалалтад хамгаалалтын бүх төрлийн аргыг тууштай нэвтрүүлэх
2. Иргэд, хилчдэд хилийн дэглэмийг хүндэтгэн сахих үзэл, хүмүүжил төлөвшүүлэх
3. Хил залгаа болон бусад орны хил хамгаалалтын байгууллагатай тогтоосон харьцаагаа хөгжүүлэх зэрэг болно.

Бид төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, хил хамгаалах байгууллагын стратегийн зорилтуудыг хил хамгаалалтад нэвтрүүлэхэд анхаарч ажиллах ёстой.

Мэдээж аливаа зорилтыг дэвшүүлэхэд амархан бөгөөд харин хэзээ, ямар үр дүнд ямар дарааллаар хүрэх, эцсийн үр дүн нь улсын хил хамгаалалтад хэзээ бүрэн гарах, хэрхэн хэрэгжүүлэх арга замаа тодорхойлон оюун санаа, хүч чадлаа дайчлан ажиллах л бидэнд үлдэж байна.